

Группийн стандарт – Бизнесийн ёс зүйн стандарт

GOV-B-001

Групп: Стандарт	Чиг үүргийн хэсэг: Ёс зүй, Хууль дүрмийн хэрэгжилт	Хуудасны тоо: 11
Хүчинтэй болох огноо: 2021 оны 7-р сарын 1	Орлох баримт бичиг: Бизнесийн ёс зүйн стандарт (2020 оны 5-р сар)	Хяналт тавьж эхлэх огноо: 2022 оны 7-р сарын 1
Хариуцагч: Ёс зүй, Хууль дүрмийн хэрэгжилт хариуцсан захирал	Баталсан огноо: 2021 оны 7-р сар	Баталсан: Хууль эрх зүй, гадаад харилцааны асуудал эрхэлсэн захирал

Зорилтот бүлгүүд:

Бүх ажилтнууд, үндсэн гэрээт гүйцэтгэгчид болон Рио Тинтогийн нэрийн өмнөөс ажиллаж байгаа холбогдох хүмүүс.

Үндсэн гэрээт гүйцэтгэгч гэдэгт 1, 2-р ангиллын гэрээт ажилтнууд болон дотоод системд нэвтрэх эрх бүхий гадны гэрээлэгчид, зөвлөхүүд болон бусад үйлчилгээ үзүүлэгчид багтана.

Шууд холбоо бүхий бодлого, стандарт, журам, удирдамжууд:

- Бидний ажлын арга барил
- Санхүүгийн эрх мэдэл олгох стандарт, журам
- Бизнесийн ёс зүйн журам
- myVoice хөтөлбөрийн журам
- Гуравдагч этгээдийг таньж мэдэх журам
- Өрсөлдөөний стандарт
- Хоригийн стандарт
- Экспортын хяналтын журам
- Үйл ажиллагааны түншлэлд хөрөнгө оруулах стандарт, журам
- Группийн худалдан авах ажиллагааны стандарт
- Группийн томилот ба зардлын журам
- Хамтарсан үйлдвэрийн стандарт ба журам
- Шинэ улс руу нэвтрэх журам
- Эрсдлийн удирдлагын стандарт
- Татварын бодлого, журмын гарын авлага

Баримт бичгийн зорилго:

Бизнесийн ёс зүйн стандарт нь Рио Тинтогийн бизнесийн ёс зүйн дараах амлалтыг биелүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ:

- хээл хахууль, авлигын бүх хэлбэрийг хориглох
 - залилан мэхлэх болон эдийн засгийн бусад гэмт хэргийн бүх хэлбэрийг хориглох
-

Баримт бичгийн нэр	Баримт бичгийн огноо	Баталсан	Хуудасны тоо
Группийн стандарт – Бизнесийн ёс зүйн стандарт	2021	Рио Тинтогийн Гүйцэтгэх Хороо	Page 2 of 11

Гарчиг

1. Зорилго	4
"Ёс зүй" гэж юу вэ?	4
Ёс зүйд яагаад анхаарах ёстой вэ?.....	4
Бидэнд ямар шаардлага тавигдах вэ?.....	4
Дагаж мөрдөөгүй тохиолдолд яах вэ?	5
Стандартын зөрчлийг хэрхэн мэдээлэх вэ?	5
Стандартын хэрэглээний талаар дэлгэрэнгүй мэдээллийг хаанаас авч болох вэ?	5
2. Гол зарчмууд	6
3. Зан үйл	6
4. Бизнесийн ёс зүйн эрсдлүүд	7
4.1 Хээл хахууль, авлига	7
4.2 Залилан ба эдийн засгийн бусад гэмт хэрэг	9
ХАВСРАЛТ	10

1. Зорилго

Рио Тинтогийн эрхэм зорилго, зорилго, үнэт зүйлсийн тунхаглал **"Бидний ажлын арга барил"**- д бид зорилго, стратегиа хэрхэн хэрэгжүүлдгээ тоймлон тодорхойлсон. Энэхүү баримт бичиг нь бидэнд, аюулгүй ажиллагаа, хамтын зүтгэл, хүндэтгэл, ёс зүй, бизнесийн төгөлдөршил гэсэн гол үнэт зүйлсийнхээ дагуу зан үйлээ хэрхэн зохистой байлгахыг тодорхой зааж өгдөг.

Бизнесийн ёс зүй нь бидний хийж буй үйлдэл болгоны суурь нь болж байдаг. Бид хаанаас ирсэн, хаана ажиллаж байгаагаас үл хамааран, зан үйлээ ёс зүйгээр удирдуулж, шийдвэр гаргахдаа ёс зүйг гол чиг шугамаа болгож, хийсэн сонголтынхоо хариуцлагыг хүлээх шаардлагыг өөртөө болон бусдадаа тавьдаг байх ёстой.

"Ёс зүй" гэж юу вэ?

Ёс зүй гэдэг нь үнэнч байх, өндөр ёс суртахуун, ёс зүйн зарчим, үнэт зүйлсийг баримталдаг, хамгийн гол нь өөрийнхөөрөө байж, буруу гэж үзсэн зүйлээ эсэргүүцэх зоригтой байхыг хэлнэ. Бидний хувьд энэ нь ажлаа хурдан, хялбар аргаар бүтээхэд бус зөв замаар хийхэд илүү анхаарна гэсэн үг.

Бид үргэлж:

- шударга, ил тодоор үйл ажиллагаагаа явуулна
- ямар нэг юм буруу санагдах үед санал бодлоо илэрхийлж, тогтсон нөхцөл байдлыг сөрнө
- олон янзын санал бодол, зөвлөгөөг эрэлхийлнэ
- өөрсдийн шийдвэр, үйлдлийн төлөө хариуцлага хүлээнэ
- бизнесээ хуулийн дагуу явуулна

Ёс зүйд яагаад анхаарах ёстой вэ?

Бидний амжилт түнш хамтрагч нар, үүний дотор орон нутгийн иргэд, засгийн газар, уугуул нутгийнхан, бизнесийн түнш, ханган нийлүүлэгч, худалдан авагч, хөрөнгө оруулагчдынхаа оролцоог ханган, хамтран ажиллах явцдаа бэхжүүлсэн харилцан итгэлцэл дээр тулгуурладаг.

Хэлсэн үгэндээ үнэнч байж, хүн бүртэй ил тод, эрх тэгш харилцсанаар бид хувь хүний хувьд ч, байгууллагын хувьд ч өөрсдийн итгэл хүлээх байдал, нэр хүндийг бэхжүүлнэ.

Бидэнд ямар шаардлага тавигдах вэ?

- Ажил албан тушаалаас үл хамааран үлгэрлэн манлайлах
- Бизнесийн ёс зүйн стандарт ("Стандарт") болон Бизнесийн ёс зүйн журамтай ("Журам") бүрэн танилцах
- Стандарт болон Журмыг үйл ажиллагаа явуулж буй бүх газартаа хэрэгжүүлэх
- Бидний шийдвэр гаргах үйл явцад нөлөөлж болох эсвэл бусдад тэгж харагдах аливаа болзошгүй эсвэл бодит сонирхлын зөрчлийг мэдүүлж, удирдан зохицуулах
- Хамтран ажилладаг хувь хүмүүст Стандарт, Журмын агуулга, холбогдох шинэчлэлийн талаар мэдэгдэх
- Бидний үйлдэл, шийдвэр нь бизнесийн ёс зүйд нөлөөлж болзошгүй тохиолдолд том, жижиг гэлтгүй бүх асуудлыг шийдвэрлэхдээ олон янзын санал бодол, зөвлөгөөг эрэлхийлэх
- Санаа зовоож буй асуудлын талаар санал бодлоо илэрхийлж, зохих ёсоор шийдвэрлүүлэх хүртэл шат ахиулан мэдээлэх
- Багийн гишүүд, хамт ажиллагсад, удирдлагын хэн нь илэрхийлснээс үл хамааран ийм санаа зовоосон асуудал байвал сонсоход бэлэн байх
- Бизнесийн ёс зүйтэй холбоотой асуудал дэвшүүлсэн хүнд эсрэг хариу арга хэмжээ авахгүй байх, хэрэв бусад хүн энэ тохиолдолд эсрэг хариу арга хэмжээ авбал тэдний талаар мэдэгдэх

Баримт бичгийн нэр	Баримт бичгийн огноо	Баталсан	Хуудасны тоо
Группийн стандарт – Бизнесийн ёс зүйн стандарт	2021	Рио Тинтогийн Гүйцэтгэх Хороо	Page 4 of 11

Дагаж мөрдөөгүй тохиолдолд яах вэ?

Стандарт болон холбогдох хууль тогтоомжийг заавал дагаж мөрдөх ёстой бөгөөд бодитой хяналт тавьж, хэрэгжилтийг нь хангана. Дагаж мөрдөөгүй тохиолдолд ажлаас халах хүртэл сахилгын арга хэмжээ авна. Хэрэв Стандарт болон холбогдох хууль тогтоомжийн хооронд зөрүү байвал аль илүү хатуу шаардлагыг нь дагаж мөрдөх ёстой.

Стандартын зөрчлийг хэрхэн мэдээлэх вэ?


Бид Стандартыг зөрчсөн, эсвэл зөрчсөн байж болзошгүй бүх тохиолдлыг мэдээлэх үүрэгтэй.

Хэрэв та энэхүү журмыг зөрчсөн талаар мэдэж байгаа эсвэл сэжиглэж байгаа бол шууд удирдлага, менежер, Рио Тинтогийн Ёс зүй, хууль дүрмийн хэрэгжилтийн хэлтэс эсвэл хүний нөөцийн түншдээ энэ талаар мэдэгдээрэй, тэд энэ асуудлыг Бизнесийн ёс зүйн газарт мэдэгдэх болно. Эсвэл та Рио Тинтогийн зөрчил мэдээлэх хөтөлбөр болох [myVoice](#) -р дамжуулан Бизнесийн ёс зүйн албанд шууд мэдээлэх боломжтой. Бодит зөрчил болон сэжигтэй тохиолдлын талаар үндэслэлтэйгээр мэдээлснийх нь төлөө ажилтанд арга хэмжээ авахыг хатуу хориглоно.

Стандартын хэрэглээний талаар дэлгэрэнгүй мэдээллийг хаанаас авч болох вэ?

Стандартын журмын шаардлагыг хэрхэн хэрэгжүүлэх талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл [Бизнесийн ёс зүйн журам](#)-г үзнэ үү.

Энэхүү стандартад заасан шаардлагаас чөлөөлөгдөх онцгой тохиолдолтой холбоотой зөвшөөрлийг Группийн захирал, Хууль эрх зүй, Гадаад харилцааны асуудал эрхэлсэн захирал, Ёс зүй, хууль дүрмийн хэрэгжилт хариуцсан захирлаас авах шаардлагатай.



Стандарт болон холбогдох хууль тогтоомжийг заавал дагаж мөрдөх ёстой бөгөөд бодитой хяналт тавьж, хэрэгжилтийг нь хангана. Дагаж мөрдөөгүй тохиолдолд ажлаас халах хүртэл сахилгын арга хэмжээ авна. Хэрэв Стандарт болон холбогдох хууль тогтоомжийн хооронд зөрүү байвал аль илүү хатуу шаардлагыг нь дагаж мөрдөх ёстой.

2. Гол зарчмууд

Бизнесийн шийдвэр гаргах болгондоо дараах гол зарчмуудыг баримтлах ёстой:

1. холбогдох бүх хууль, дүрэмд зөвшөөрсөн бөгөөд тэдгээртэй нийцсэн байх
2. Рио Тинтогийн бодлого, стандарт, журмуудтай нийцсэн байх
3. Сонирхлын зөрчилтэй боловч түүнийгээ мэдүүлээгүй хүн шийдвэр гаргахгүй байх
4. цэвэр бизнесийн зорилготой байх
5. "Бидний ажлын арга барил"-тай нийцэж байх
6. компанийн ёс зүй, сайн засаглалын нэр хүндэд эрсдэл учруулахгүй байх

3. Зан үйл

Ил тод байдал, хариуцлага нь итгэлцлийг бэхжүүлж, тогтвортой бизнесийн практикийг хөхиүлэн дэмжих гол түлхүүр юм. Ивээн тэтгэлэг, хандив, орон нутгийн иргэдэд үзүүлэх дэмжлэг, гуравдагч этгээдээс хүртэх ашиг өгөөж, болзошгүй мөн/эсвэл бодит сонирхлын зөрчлийг мэдээлэх нь ёс зүй, нээлттэй байдлын соёлыг дэмжинэ.

Сонирхлын зөрчил гэдэг нь бидний ажил үүргээ гүйцэтгэх арга барилд нөлөөлөх эсвэл нөлөөлнө гэж үзсэн хувийн, санхүүгийн мөн/эсвэл улс төрийн үйл ажиллагаа, холбоо хамаарал, ашиг сонирхлыг хэлнэ. Эдгээр нөхцөл байдал үүсэх буюу үүсэж магадгүй тохиолдолд удирдлагадаа нэн даруй мэдээлэх нь чухал бөгөөд ингэснээр бид нөхцөл байдлыг эхнээс нь зөв удирдах боломжтой болох юм. Эсхүл Ёс зүй, хууль дүрмийн хэрэгжилтийн албанаас зөвлөгөө аваарай.

Сонирхлын зөрчил нь олон янзаар илэрч болно. Жишээ нь:

- Таны гэр бүлийн гишүүн, найз нөхөд боломжит эсвэл одоогийн ханган нийлүүлэгч эсвэл худалдан авагчаас ашиг хүртдэг, тэдгээртэй холбоо хамааралтай, эсвэл тэдэнд ажилладаг байх;
- Таны гэр бүлийн гишүүн, найз нөхөд бас Рио Тинтод ажилладаг бөгөөд таны гаргах шийдвэр тэдэнд нөлөөлөхөөр эсвэл тэд шийдвэр гаргахад оролцохоор бол;
- Та, таны гэр бүлийн гишүүд, найз нөхөд Рио Тинтогийн сонирхож буй хөрөнгийг өмчилдөг тохиолдолд;
- гэр бүлийн гишүүн, найз нөхөд төрийн албан тушаалтан бөгөөд Рио Тинтотой харилцаатай ажилладаг эсвэл харилцаж магадгүй тохиолдолд.

Бид өөрсдийгөө болон компаниа хамгаалахын тулд Бизнесийн ёс зүйн бүртгэл -р дамжуулан ашиг сонирхлын зөрчил үүссэн эсвэл үүсэж болзошгүй талаар мэдэгдэж, нөхцөл байдлыг удирдлагуудтайгаа хамтран удирдан зохицуулах ёстой.

Баримт бичгийн нэр	Баримт бичгийн огноо	Баталсан	Хуудасны тоо
Группийн стандарт – Бизнесийн ёс зүйн стандарт	2021	Рио Тинтогийн Гүйцэтгэх Хороо	Page 6 of 11

4. Бизнесийн ёс зүйн эрсдлүүд

4.1 Хээл хахууль, авлига

Групп ямар дүрэмтэй вэ?

Рио Тинтод ажиллаж байгаа болон төлөөлж буй нийт ажилтнууд, үндсэн гэрээт гүйцэтгэгчид, тэдгээртэй хамаарал бүхий этгээдүүд хээл хахууль, авлигын хэрэг үйлдэх, ийм үйлдлийг дам буюу илэрхий зөвшөөрөх, оролцохыг хориглоно.

Хээл хахууль гэж юу вэ?

Аливаа хүн тодорхой үр дүн эсвэл үйлдэлд зохисгүй байдлаар нөлөөлөх эсвэл зохисгүй байдлаар ажиг олж авах эсвэл баталгаажуулах зорилгоор засгийн газрын албан тушаалтан зэрэг (эсвэл тухайн албан тушаалтны гэр бүлийн гишүүн эсвэл найзад) аливаа этгээдэд санхүүгийн эсвэл бусад давуу тал шууд болон шууд бусаар санал болгох, амлах эсвэл олгох эсвэл эдгээр үйлдлийг хийхийг зөвшөөрөх зэрэг нь хээл хахууль юм. Түүнчлэн аливаа этгээд Рио Тинтогоос ажил бизнес, бусад аливаа давуу тал олж авсны хариуд танд ямар нэгэн зүйл санал болгох, амлах, бэлэг өгөх эсвэл та өөрөө (өөртөө эсвэл өөр хэн нэгнээс) хүсэх, шаардах нь хээл хахууль юм.

Та дараах нөхцөл байдалд Стандартын 2-р хэсэгт заасан гол зарчмуудыг санаж, таны үйлдэл, тухайн нөхцөл байдлыг бусад хүмүүс хэрхэн хүлээн авч болохыг онцгой анхаарах ёстой:

Тулгарах нөхцөл байдал...	Бид юу хийх ёстой вэ:
гуравдагч этгээдээс ашиг өгөөж хүртэх (ө/х бэлэг, зоог, аялал, зочлох, томилолтын зардал зэрэг үнэ бүхий зүйл авч, өгөлцөх)	Бизнесийн ёс зүйн бүртгэл -д бүртгүүлэн мэдүүлж, урьдчилан зөвшөөрөл авах (хэрэв Бизнесийн ёс зүйн журамд заасан шаардлагыг* хангаж байвал)
болзошгүй эсвэл бодит сонирхлын зөрчил (ө/х та эсвэл таны ойр дотны хэн нэгний хувийн ашиг сонирхол нь Рио Тинтогийн ашиг сонирхолтой зөрчилдөх, ийм нөхцөл үүсгэх алба үүрэг хаших эсвэл ашиг сонирхлын зөрчил гарч болзошгүй гэж үзэх)	<ul style="list-style-type: none">ийм нөхцөл байдал болон хээл хахууль, авлига гарах боломжийг бүрдүүлж болзошгүй эрсдэл илэрвэл удирдлагадаа нэн даруй мэдэгдэж, Ёс зүй, хууль дүрмийн хэрэгжилтийн албанаас зөвлөгөө аваарайБизнесийн ёс зүйн онлайн бүртгэл-ээр дамжуулан мэдэгдэж, Бизнесийн ёс зүйн бүртгэл -д бүртгүүлэн мэдүүлж, нөхцөл байдлыг удирдлагатайгаа хамтран удирдан зохицуулах*
хөнгөвчлөх төлбөр (ө/х зөвшөөрөл эсвэл захиргааны процессыг тургэвчлэхийн тулд засгийн газрын албан тушаалтнуудад төлбөр өгөх). Эдгээр нь амь насанд аюул заналхийлснээс бусад тохиолдолд хориотой	<ul style="list-style-type: none">хувийн аюулгүй байдалд ямар нэгэн байдлаар аюул заналхийлээгүй л бол төлбөр хийхгүй байхтөлбөр өгсөн эсвэл шаардсан бол аль болох даруй мэдээлж, зохих ёсоор бүртгэх*
Рио Тинтогийн өмнөөс ялангуяа засгийн газрын албан тушаалтан эсвэл агентлагтай хэлэлцээ хийх, төлөөлөх, зуучлах эсвэл үйл ажиллагаа явуулах төлөөлөгч, зөвлөх авч ажиллуулах	<ul style="list-style-type: none">зохих ёсоор эрсдлийн үнэлгээ хийх*гуравдагч этгээдийг ажиллуулахаас өмнө зөвлөлдөж, зөвлөгөө авах*Гуравдагч этгээдийг таньж мэдэх журмын дагуу шаардлагатай бол гуравдагч этгээдийн магадлан шинжилгээ хийлгэхийг хүсэхажил гүйлгээг нарийн бүртгэж, дотоод бүртгэл, мэдээллийг ил тод байлгах
гуравдагч этгээдийг ажиллуулах (жишээ нь: далайн худалдааны	<ul style="list-style-type: none">Гуравдагч этгээдийг таньж мэдэх журам -н дагуу гуравдагч этгээдийн магадлан шинжилгээний хүсэлт гаргах

Баримт бичгийн нэр	Баримт бичгийн огноо	Баталсан	Хуудасны тоо
Группийн стандарт – Бизнесийн ёс зүйн стандарт	2021	Рио Тинтогийн Гүйцэтгэх Хороо	Page 7 of 11

төлөөлөгч, харилцагч, ханган
нийлүүлэгч)

нэгтгэх ба худалдан авах ажиллагаа (үүнд группийн удирдлагад байдаг эсэхээс үл хамааран шинэ хийх хөрөнгө оруулалт, хамтарсан үйлдвэрийн гэрээ хамаарна)

- Гуравдагч этгээдийг таньж мэдэх журам -н дагуу гуравдагч этгээдийн магадлан шинжилгээний хүсэлт гаргах
- Төлөвлөж буй зорилтот бүлэгт эсвэл түншид бизнесийн ёс зүйн нийцлийн хөтөлбөрийн үнэлгээ хийлгэх хүсэлт гаргах

тэтгэлэг, хандив, орон нутгийн иргэдэд чиглэсэн санхүүгийн болон эд хөрөнгийн дэмжлэг

- Суурь шинжилгээ хийлгэх хүсэлт гаргаж, Гуравдагч этгээдийг таньж мэдэх журам -н дагуу гуравдагч этгээдийн магадлан шинжилгээ хийлгэх
- хэрэв мөнгөн дүн 5000 ам.доллараас дээш бол Бизнесийн ёс зүйн бүртгэл* -д бүртгүүлж, энэ стандартын гол зарчмуудыг хангасан гэсэн зөвшөөрөл авах

*Эдгээр шаардлагыг хэрхэн биелүүлэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Бизнесийн ёс зүйн журам-г үзнэ үү. Мэдүүлгийг Бизнесийн ёс зүйн бүртгэл -г ашиглан онлайнгаар гаргана.

Хувийн болон Рио Тинтогийн нэр хүнд, итгэл хүлээх байдалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй нөхцөл байдлуудыг таньж тодорхойлохын тулд “Бизнесийн ёс зүйн эрсдэлд хөтөлж болзошгүй нөхцөл байдал” гэсэн гарчигтай Хавсралтыг үзнэ үү.

4.2 Залилан ба эдийн засгийн бусад гэмт хэрэг

Групп ямар дүрэмтэй вэ?

Рио Тинтод ажиллаж байгаа болон төлөөлж буй нийт ажилтнууд, үндсэн гэрээт гүйцэтгэгчид, тэдгээртэй хамаарал бүхий этгээдүүд залилан ба эдийн засгийн бусад гэмт хэргийг санаатайгаар үйлдэх, холбогдох буюу оролцохыг хориглоно.

Залилан ба эдийн засгийн бусад гэмт хэрэг гэж юу вэ?

Та өөртөө (эсвэл ойр дотны хүндээ) давуу тал олгох эсвэл бусдад гарз хохирол учруулах зорилгоор санаатайгаар хуурамч мэдэгдэл хийх, үйлдэл, эс үйлдэл хийх, нуун дарагдуулсан тохиолдолд залилан ба эдийн засгийн бусад гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ.

Залилан гэдэг нь Рио Тинтогийн нөөц, хөрөнгийг санаатайгаар зүй бусаар ашиглах, завших зэргээр ажилтан Рио Тинтод гарз хохирол учруулан хувьдаа ашиг хонжоо, давуу тал олохыг хэлнэ. Үүнд огт гараагүй зардал нэхэмжилж эсвэл Томилолт, зардлын удирдлагын журмыг зөрчиж хуурамч эсвэл засвартай нэхэмжлэх үйлдэх, илгээх, эсвэл боловсруулах, компанийн бүртгэл, мэдээллийг хуурамчаар засах, нийлүүлэгчийн үндсэн гэрээний өгөгдөл эсвэл банкны дансыг гуйвуулан өөрчлөх, шаардлагатай үед чухал мэдээллийг шударга бусаар нуун дарагдуулах эсвэл мэдэгдэхгүй байх зэрэг хамаарна.

Эдийн засгийн бусад гэмт хэрэгт мөнгө угаах, террорист байгууллагын санхүүжилт, татвараас зугтах нөхцлийг бүрдүүлэхтэй холбоотой нөхцөл байдал, зохицуулалт орно.

Баримт бичгийн нэр	Баримт бичгийн огноо	Баталсан	Хуудасны тоо
Группийн стандарт – Бизнесийн ёс зүйн стандарт	2021	Рио Тинтогийн Гүйцэтгэх Хороо	Page 9 of 11

ХАВСРАЛТ

Бизнесийн ёс зүйн эрсдэлд хөтөлж болзошгүй нөхцөл байдал

Ажил хэрэг явуулах явцад учирч болох бодит нөхцлүүдийн зарим жишээг энэ хэсэгт орууллаа. Энэ жагсаалт нь иж бүрэн биш боловч, бизнесийн ёс зүйд нөлөөлж болзошгүй шийдвэр гаргахаасаа өмнө түр азнаж, нөхцөл байдлыг нягтлан үзэхэд тань тусална. Нэмэлт удирдамжийг [Бизнесийн ёс зүйн журам](#) -с авна уу.

Анхаар! Та дараах тохиолдолд эрсдэлд орж болзошгүй:

Болзошгүй эсвэл бодит сонирхлын зөрчил гарах

- ✓ Таны гаргах гэж байгаа шийдвэрээс таны найз нөхөд, гэр бүлийн гишүүн эсвэл хувьцааг нь эзэмшдэг компани ашиг тус хүртэж болзошгүй
- ✓ Шийдвэр гаргахад тань хувийн хүчин зүйлс нөлөөлж байгаа мэт санагдах
- ✓ Оролцогч тапууд таны хувийн ашиг сонирхол гаргах шийдвэрт чинь нөлөөлнө гэж үзэж байж болзошгүй
- ✓ Тухайн асуудал сонинд гарвал танд эвгүй санагдахаар байвал
- ✓ Та нөгөө талыг (жишээ нь: ханган нийлүүлэгч/гэрээт гүйцэтгэгч) таны өөрийн гэр бүл/найз нөхөдтэй хамаарах сонирхлын зөрчилтэй байна гэж үзэх

Засгийн газрын албан тушаалтнууд, засгийн газрын агентлаг эсвэл уламжлалт эрх бүхий байгууллагатай ажил хэрэг явуулах

- ✓ Танаас зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл батлах/олгох явцыг түргэсгэхийн тулд төлбөр мөнгө хүсэх
- ✓ Шийдвэрт нөлөөлөхийн тулд орон нутгийн иргэдэд санхүүгийн дэмжлэг, хандив эсвэл тэтгэлэг өгөхийг танаас хүсэх
- ✓ Танаас засгийн газрын эсвэл орон нутгийн хөгжлийн санд хуулиар шаардаагүй хандив өгөхийг шахаж шаардах
- ✓ Танаас орон нутгийн оролцогч талаас зохисгүй төлбөр мөнгө хүсэх

Төлөөлөгч, зуучлагч, зөвлөх гэх мэт гуравдагч талтай харилцах

- ✓ Томилогдсон гуравдагч этгээд Рио Тинтод хүлцэж болохгүй зан үйлдэл гаргах
- ✓ Засгийн газрын хүсэлтээр тодорхой нэг гуравдагч этгээдтэй харилцах, хэлцэл хийх үүрэг авах эсвэл нөлөөлөл учруулах
- ✓ Таны дарга танд уулзалтын бүртгэл мэдээллийг хадгалахгүй байх эсвэл тэмдэглэлээ устгах заавар өгөх
- ✓ Таны хамт ажиллагсад тодорхой нэг хэлцэл, гэрээг нууц гэж мэтгэх
- ✓ Зуучлагч шагнал, урамшуулал, амжилтын хураамж хүсэх эсвэл ийм хүсэлт нь тухайн нөхцөл байдалд үндэслэлгүй цаг хугацааны шахаптаас хамааралтай байх
- ✓ Нөгөө тал эсвэл тэдний туслан гүйцэтгэгчдийн талаар гуравдагч этгээдийн магадлан шинжилгээг хангалтгүй явуулах
- ✓ Гуравдагч этгээд эсвэл зуучлалын төлбөр хураамж нь үндэслэлгүй өндөр эсвэл зах зээлийн стандартаас дээгуур байх

Бизнес хөгжлийн шинэ боломжуудыг судлах

- ✓ Группийн удирддаг хамтарсан үйлдвэрийн түншид гуравдагч этгээдийн магадлан шинжилгээ болон бизнесийн процесс, хяналтын үнэлгээг хангалтгүй хийсэн байх
- ✓ Рио Тинтогийн бизнесийн ёс зүйн эрсдлүүдийг зохих ёсоор харгалзан үзэлгүйгээр хөрөнгө оруулалт хийх

Та худалдан авалт/хангамжийн сүлжээний үйл ажиллагааг удирддаг бол

Баримт бичгийн нэр	Баримт бичгийн огноо	Баталсан	Хуудасны тоо
Группийн стандарт – Бизнесийн ёс зүйн стандарт	2021	Рио Тинтогийн Гүйцэтгэх Хороо	Page 10 of 11

- ✓ Тендер эсвэл гэрээ хэлэлцээний явцад та зохисгүй, хэтрүүлсэн байдлаар зочлон дайлах, эсвэл таныг ийн дайлах санал тавих
- ✓ Тодорхой ханган нийлүүлэгчдэд тааламжтай нөхцөл бүрдүүлэх эсвэл тодорхой ханган нийлүүлэгчдийг хасах зорилгоор техникийн үзүүлэлтийг өгөх мөн/эсвэл гуйвуулж өөрчлөх
- ✓ Худалдан авалтын процесс/батлах процессыг зальдахын тулд гэрээний үнийн дүнг хуваах
- ✓ Гэрээний менежментийн залилан үйлдэх (жишээ нь: ажил бүрэн гүйцэтгэхгүй байх, явцыг буруу мэдээлэх, өөрчлөх захиалгыг зүй бусаар ашиглах)

Та зардал баталдаг бол

- ✓ Үндэслэлгүй, зохисгүй эсвэл зөвшөөрөгдөөгүй зардлын нэхэмжлэл илгээх
- ✓ Зохих нотлох баримт бичиггүй зардлын нэхэмжлэл илгээх